



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 12 өдөр

Дугаар А/559

Арвайхээр

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн
бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед авах
зарим арга хэмжээний тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, аймгийн Онцгой комиссын 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 38 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улсын Онцгой комиссын 2021 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 1432 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу аймгийн хэмжээнд дотоодын тэмцээн, уралдаан болон мэргэжлийн спорт холбоодын лигийн тэмцээн, соёл урлагийн зэрэг үзвэр үйлчилгээний арга хэмжээг 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн заал, танхимын 50 хувийн дүүргэлттэйгээр нээж, дархлаа сэргээх 3 дугаар тунд хамрагдсан иргэдэд үйлчилгээ үзүүлэхийг зөвшөөрсүгэй.

2.Дээрх шийдвэрийн хүрээнд иргэн аж ахуйн нэгж байгууллагууд зохион байгуулах арга хэмжээний зөвшөөрлийг аймаг, сумдын шуурхай штабаас авч, хяналт тавьж, бүртгэл хөтөлж ажиллахыг аймгийн Онцгой комиссын орлогч, Онцгой байдлын газрын дарга, (дэд хурандаа Д.Одонбаяр), Цагдаагийн газрын дарга (цагдаагийн хурандаа Б.Мөнх-Эрдэнэ), аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын дарга (Л.Шиваанврдэв). Мэргэжлийн хяналтын газрын дарга (С.Дуламсүрэн), аймаг сумдын шуурхай штабын бүрэлдэхүүн болон Сумын Засаг дарга нарт даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч, шуурхай штабын дарга (И.Доржсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101182